

“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК–ИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ИЛТГЭЛ.

Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ, ТУЗ-ийн дарга, гишүүдээ. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж, мэндчилье.

Өнгөрөгч 2020 оны 4-р сард хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хурлаас өнөөдрийг хүртэлх хугацааны үйл ажиллагааны тайланг нэгтгэн та бүхэнд танилцуулж байна.

Тайлангийн хугацаанд **“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК**-ийн хувьд ярьж төлөвлөж байсан томоохон төсөл хөтөлбөрүүд тухайлбал “Хувьцаат орон сууц” төсөл, “Хувьцаат авто хүлэг” төсөл эхлэн үйл ажиллагаа явуулсан цаг хугацаа байлаа.

Хийж хэрэгжүүлсэн ажлаа уламжлал ёсоороо дараах 3 чиглэлд багцлан та бүхэндээ тайлагнаж байна.

- 1. Дотоод ажлын талаар**
- 2. Төсөл хөтөлбөрүүдийн явцын талаар**
- 3. Цаашдын зорилтын талаар** гэсэн 3 бүлэгт.
- 4.**

НЭГ: ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

Тайлангийн хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулийн дагуу 1 удаа /2020,04,30/, ээлжит бус хурлыг 1 удаа /2020,12.13/ зарлан хуралдуулж, төлөвлөгдсөн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсний зэрэгцээ ТУЗ-ийн хурлыг 4 удаа хуралдуулж нийт нийт 12 асуудлыг хэлэлцэн хамтын шийдвэр гаргажээ. Хэлэлцсэн асуудлын дотор 3 нэр бүхий журам боловсруулагдан батлагдсан байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудад хандан 77 албан бичиг бүхий тайлан, тайлбар, дүгнэлт, хүсэлт явуулсан ба нэр бүхий хамтран ажилладаг байгууллагуудаас ирүүлсэн 20 аран албан бичгийг хүлээн авч хэрэгжүүлж ажилласан байна.

Хууль, журмаар зохицуулагддаг тайлан баланс гаргах, мэдээ мэдээлэл хүргэх ажлууд зөрчилгүй явж байна.

Хувьцаат орон сууц төслийн хүрээнд ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаварын дагуу барилга угсралтын 8 компани хувь хүмүүстэй нийт 325 барилга захиалгын гэрээ хийж ажил ажиллалаа. Гэрээний үүргийн үнийн дүн 28 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Компанийн дотоод бүтцийг өөрчилж 4 хэлтэс 14 ажилтны бүтцийг бий болгоод байна.

Төсөлд хамрагдсан хувьцаа эзэмшигчдийн хувийн хэрэг нээж, ахив үүсгэж ажлыг хүн тус бүр дээр хийж гүйцэтгэлээ.



ХОЁР: ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ЯВЦЫН ТАЛААР:

Өнгөрөгч 2020 оны 8-р сард эхлүүлсэн “ХУВЬЦААТ ОРОН СУУЦ” төслийн үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэн та бүхэнд танилцуулж байна.

Бидний олон жилийн хугацаанд боловсруулан шинэчлэж, төслийг саадгүй , үр дүнтэй эхлүүлэн явуулах нийгмийн болон үйл ажиллагааны тохиромжтой цаг хугацааг хүлээн бэлтгэсэн томоохон төсөл болох уг төсөл нь 2020 оны 03-р сарын 12-ны өдөр хуралдсан ТУЗ-ийн хурлаар баталсан

“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХ ТӨСЛИЙН ЖУРАМ”-ын хүрээнд зохион байгуулагдан явагдаж байна.



Журам батлагдсантай холбогдуулан компанийн гүйцэтгэх захирал, ажлын албанд өгөгдсөн үүрэг даалгаварын дагуу

1. Төсөл хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргах, эхлэлийн гүйцэтгэлүүдийг үе шаттайгаар төлөвлөх, төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг эзэнжүүлэх, цаг хугацааг тодотгох зэрэг ажлуудыг төлөвлөн гаргалаа. Ажлын төлөвлөгөөнд Төсөлд хэрэглэгдэх мөнгө санхүүгийн боломжуудыг нэгтгэн гаргах, хөрөнгө татан төвлөрүүлэх цаг хугацааг үе шаттай төлөвлөх, төсөлд оролцох хүн хүчний байршил, тоо хэмжээг тодотгох, холбоо тогтоон танилцуулга, тайлбар хийх, улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжиж байгаа орон сууцны судалгаануудыг нэгтгэн гаргах, барилга угсралтын компаниудтай харилцаа тогтоох, хамтран ажиллах санал солилцох зэрэгт голлон төлөвлөгдөн явагдсан билээ.
2. Мөн төслийн журмын хүрээнд түүнд хэрэглэгдэх 12 төрлийн бичиг баримтуудыг боловсруулан бэлтгэж баталгаажуулах, олшруулах ажлуудыг зохион байгуулан бэлтгэсэн байна. Үүнд:
 - Төслийн журмын хүрээнд холбогдох дэд журмуудыг боловсруулан гаргах
 - Төслийн хураангуй оноосон нэршлийг гаргах
 - Хувьцаа эзэмшигчидтэй хийх гэрээний эхийг бэлтгэн гаргах
 - Хамтран ажиллах байгууллага, хамт олонтой хийх гэрээг боловсруулах
 - Орон сууц захиалах хуудсыг боловсруулах
 - Төсөлд оролцогчдийн хувийн мэдээллүүдийн хуудас бэлтгэх
 - Дараа дараагийн төслүүдийн судалгаа шинжилгээний мэдээллийг цуглуулах
 - Хувьцаажуулах бодлогын бичиг баримтыг боловсруулах, дарааллыг тогтоох
 - Орон сууцжуулахтай холбогдох гэрээ бүртгэл судалгааны бичиг баримтыг боловсруулах зэрэг ажлуудыг гүйцэтгэжээ.

Ажлын үр дүнд



- Хамтын ажиллагааны гэрээ
- Орон сууц захиалгын хуудас
- Өмчилсөн газрын судалгааны хуудас
- Хувьцаа захиалгын хуудас
- Иргэн төвлөрсөн хадгаламжинд данс нээлгэх гэрээ
- Нууцлалын гэрээ
- Хөлсөөр ажил үйлчилгээ эрхлэх гэрээ
- Орон сууц сонголтын гэрээ зэрэг бичиг баримтууд гарч өнөөдөр үйл ажиллагаанд хэрэглэгдэж байна.

Компанийн оффисыг ажил хэрэг явуулахад тохиромжтой болгон өөрчилсөн ба зарим тохижилтийн ажлуудыг хийж гүйцэтгэлээ.





Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дараагаас төсөл хөтөлбөрүүдийг эхлүүлэх, хамтрагч байгууллагуудтай удаа дараагийн уулзалтуудыг идэвхитэй явуулсны үндсэн дээр өнөөдрийн байдлаар 5 бүлэг байгууллага, 8 гаран барилга угсралтын байгууллагуудтай хамтын ажиллагааны болон ажил үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна.

Бидний хамгийн анхлан хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажилласан хамт олон бол МОНГОЛЫН БАГШ НАРЫН ШИНЭ ЗУУН ЗӨВЛӨЛДӨХ ЗӨВЛӨЛ НҮТББ юм.



Тус байгууллага нь Монголын багш нарын 7-р их хурлаас байгуулагдсан, боловсролын салбарын багш ажилтаны нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий байгууллага бөгөөд байгуулагдсан цагаасаа эхлэн багш нарын нийгмийн асуудлууд тэр дундаа багш нарыг орон сууцжуулах асуудлыг анхаарлынхаа төвд байлгаж, төр засгийн шат шатны үүрэг чиглэл бүхий байгууллагууд, хувийн хэвшлийн бүхий л байгууллагуудтай дээрхи асуудлаар ярилцаж, судалгаа

шинжилгээ хийсэн, боломж гарцуудыг эрэлхийлсэн ажил хэрэгч байгууллага байлаа.

Хэд хэдэн удаагийн ажил хэрэгч уулзалтын дүнд бид хамтран ажиллаж санамж бичиг байгуулан “ХУВЬЦААТ ОРОН СУУЦ” төслийг хамтран хэрэгжүүлэхээр эрх хэмжээ, үүрэг хариуцлагаа тодорхойлон ажлаа эхлүүлцгээсэн билээ.



Энэ оны 8-р сарын эхээр эхлүүлсэн бидний ажил өнөөдөр 1200 гаран багш, боловсролын салбарын ажилтныг хамран өргөжсөн бөгөөд улмаар салбарлан эмч эмнэлэгийн ажилтан, урлаг соёлын ажилтан, зарим үүрэг чиглэл бүхий ТББ-ууд, тээврийн салбарыг хамран өргөжөөд байна.



Мөн төслийг дэмжиж Эмч эмнэлэгийн байгууллагын салбарыг төлөөлөн “МОНГОЛЫН ЭМНЭЛЭГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЦЭГЦ ТАНХИМ” ТББ-тай хамтран ажиллах гэрээг үзэглээд байна. Хамтрагч маань 3000 эмч эмнэлэгийн ажилтныг төсөлд хамруулахаар төлөвлөн ажлаа эхлүүлээд байна.



Монголын урлаг соёлын байгууллагын ажилтан ажилчид, байгууллагууд төсөлд хамрагдах саналаа ирүүлсэний зэрэгцээ Түвшинтөгс даргатай Улсын дуурь бүжгийн эрдмийн театр хамтран ажиллах гэрээ байгуулж 100 гаруй уран бүтээлчдээ нэгтгээд байна.



Төсөлд олон чиглэлийн үүрэг гүйцэтгэж байгаа Байгууллага хамт олон нэгдсэн бөгөөд Гэрлийн өргөө нэгдэл, Монгол тэнгэр үнэн ТББ өөрийн 80 орчим гишүүдийн хамт төслийн үйл ажиллагаанд оролцож байна.

Өнөөдрийн байдлаар Хувьцаат орон сууц төсөлд нийт 1200 гаруй хувьцаа эзэмшигч оролцож байгаагийн дотор эхний 69 багш хувьцаа эзэмшигч орон сууцандаа ороод тав тухтай амьдарч байна.



Төслийн 18 дахь хоног дээрээ буюу 2020 оны 08 дугаар сарын 21-нд эхний 32 багшдаа орон сууцны түлхүүрийг гардуулан эдгээр багш нар маань шинэ байрандаа тухай сайхан өвөлжөөд байна.



Манай 32 хувьцаа эзэмшигчийн амьдарч буй ХОС ЦАЙЗ хотхоны барилгын зураг



Хувьцаат орон сууц төслийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байгаа хамт олон бол манай барилга угсралтын компаниуд байлаа.

Одоогоор 8 барилгын компанитай барилга захиалгын гэрээ байгуулан ажиллаж байгаа ба нийт 325 орон сууц захиалан бариулж байна. Энэ оны 4-5-р сард нийт захиалгын 150 орон сууц ашиглалтанд орох төлөвлөгөөтэй байна. Цаашид хамтран ажиллах санал солилцож буй олон байгууллага байна.



Энэ оны төгсгөлд ашиглалтанд орох Бүргэд констракшны 3800 айлын орон сууц бүхий ӨРНӨХ хороолол төсөлд 35 орон сууцны захиалга хийгдсэн бөгөөд цаашид тус хороололд бүхий 1000 орон сууц бүхий БАГШ хотхон, мөн 1000 орон сууц бүхий ЭМЧ хотхон байгуулахаар хамтарсан төлөвлөлт хийгдэж байна.

Манай төслийн гол бүтээгдэхүүн болох барилга угсралтын ажлын үр ашигай байлгах үүднээс БАРИЛГА УГСРАЛТЫН ӨНДӨР ТЕХНОЛОГЫН СУДАЛГААНЫ АЖЛУУДЫГ ИДЭВХИЙЛЭН ХИЙЖ зарим үр дүнд хүрээд байна. Энэ тухай мэдээллийг та бүхэндээ жич хүргэх болно. Хамгийн товч мэдээлэл гэвэл энхүү технологээр барилга угсралтын ажлын хугацааг 8-10 дахин богиносгох боломжтой юм.



Баянзүрх дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэрт бүтээн байгуулагдаж буй СЭРЭНЭ ТАУН хотхонд 96 айлын 2 блок орон сууцанд тус дүүргийн 79-р сургуулийн багш нар маань орон сууцаа захиалаад байна. Захиалгыг нэмэгдүүлэх ажлаар хэлэлцээр хийгдэж байна.



Барилга угсралтын, Барилгын зургийн компаниудтай хамтран ШИНЭ ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН схемийг ярилцаж байна.



Компани хөрөнгө татан төвлөрүүлэх, нэмэлт хөрөнгө босгох ажилдаа орж Хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүд, баг хамт олонтой хамтран компанийн “НОГООН БОНД” гаргах ажлыг 3 үе шаттай төлөвлөн судалгаа тооцооллын дагуу эхний ээлжинд 3тэрбум 500 сая төгрөгийн үнэ бүхий 3500 ширхэг бонд гарган арилжаалж эхлээд байна.



Анхны бонд эзэмшигчид

Хаалттай бондыг зах зээл дээр борлуулах ажлыг мэргэжлийн байгууллага болох "МОНСЕК үнэт цаасны компани" ХХК эрхлэн явуулж байна.



Бонд эзэмшигчдэд гардуулж буй батламж



Төслийн эхэнд бид 400 хувьцаа эзэмшигчтэй байсан бол өнөөдөр 1600 гаруй хувьцаа эзэмшигчтэй өнөр айл болоод байна. Төсөлд Үндсэн хувьцаа эзэмшигчид идэвхитэй оролцож байгаад баяртай байна.

Хувьцаа эзэмшихээр данс нээж захиалга өгсөн хүмүүсийн банк дахь арилжааны анс нээх ажил хүлээгдэж байгаад, мөн тэдэнд санал болгох хувьцааны олдоц муу байгаад анхаарч ажлаа зохицуулан яаралтай нэмэлт хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэх ёстой болж байна.

Төслийг хөдөө орон нутагт түгээн хэрэгжүүлэх бэлтгэл хийгдэж Дорноговь аймгийн Зүүн баян суманд 9 орон сууц бэлтгэн тус сүмын 4-р цэцэрлэгийн багш ажилтануудтай гэрээ байгуулан орон сууцжуулах ажлаа хөдөө орон нутагт эхлүүлээд байна. Барилга баригдаж дуусан Улсын комист хүлээлгэн өгөх ажил явагдаж байна.



Хамтран ажиллаж буй багш нарын байгууллагын төлөөллийг салбарын сайд хүлээн авч ажилтай танилцаж, цаашид хамтран ажиллах чиглэл баримталж буйд талархалтай байна.



Компанийн 2 дахь төсөл болох Хувьцаат авто хүлэг төслийн үндсэн бичиг баримтын боловсруулалтыг дуусган баталж, бүртгэлийн ажлыг эхлүүлээд 50 гаран хүн захиалга өгч эхний ээлжийн 4 машин эзэндээ очоод байна.



“Хувьцаат авто хүлэг” төсөл нь “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” хувьцаат компанийн үндсэн төслүүдийн нэг бөгөөд “Хувьцаат орон сууц” төслийн үргэлжлэл төсөл болно. Уг төсөл нь манай хувьцаа эзэмшигчдийн өөрсдийн санаачлан боловсруулсан төсөл төдийгүй өнөөгийн нийгмийн амьдралын шаардлагаар урган гарч байгаа чухал ач холбогдол бүхий төсөл юм.

- ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ АВТО МАШИНЖУУЛАХ, ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ ЗОРИЛГОТОЙ. :
- БАГТААМЖ: НИЙТ 5000 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ХАМРАГДАНА



- АВТО МАШИНЫ ҮНЭ, НИЙЛҮҮЛЭЛТ. БОРЛУУЛАЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ.

Төслийн баг олон жил авто машины импорт эрхэлж, гадны байгууллага хүмүүстэй худалдааны сайн түнш болсон байгууллага, хувь худалдаачдын ажлыг хүндэтгэж тэдэнтэй зэрэгцэн импортын худалдаа хийхээс татгалзаж байна. Харин шударга сайн худалдаачидтай хамтран ажиллах бодлого баримтална.

Өнөөдөр худалдаачдын нийлүүлж байгаа энэ төрлийн машин манай зах зээл дээр хангалттай тоон үзүүлэлттэй байна.

- БОРЛУУЛАЛТЫН БОДЛОГО.

- Урьдчилсан захиалга авна.
- Сар бүр 100ш ээс доошгүй борлуулалт хийнэ.
- Урьдчилгаа үнийн дүнгийн 30 хувь төлнө.
- Үлдэгдэл төлбөрийг
 - 2-р үеийн харриер машинд сарын 300 000 төг
 - 3-р үеийн харриер машинд сарын 500 000 төг
- Хүү тооцохгүй
- Бусад шалгуур тавихгүй

- ТӨСӨЛД ХАМРАГДАХ ЗАРЧИМ, ДАРААЛАЛ.

1. Төсөлд хамрагдагсад компанийн хувьцаа эзэмшигч байна.
2. Хувьцаа эзэмшигч тус бүртэй “Авто машинжуулах хамтын ажиллагааны гэрээ” байгуулна.
3. Төслийн санхүүг тусдаа бие даасан дансаар явуулна
4. Төсөлд авто засвар, үйлчилгээ, худалдааны мэргэжлийн компаниуд мэргэжлийн өндөр түвшний үйлчилгээгээр хамтран ажиллана.
5. Төслөөр гарах машиныг бүрэн үзлэг үйлчилгээ хийж баталгаа гаргана.
6. Машин “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн нэр дээр гэрчилгээжинэ.
7. Машинд бүрэн даатгал хийгдэнэ.
8. Машиныг эзэмшигчид актаар хүлээлгэн өгнө.
9. Машины засвар үйлчилгээг тусгай сервист хөнгөлөлтэй, дараа төлбөрт үнээр хийнэ.
10. Хувьцаа эзэмшигчид хувьцааны үнийн өсөлтөөр болон ногдол ашгиар олсон орлогоо эргэн төлөлтөд тооцуулж болно.
11. Машины үнэ төлөгдөж дуусахад тээврийн хэрэгслэлийн гэрчилгээг эзэмшигчид саадгүй шилжүүлж өгнө.
12. Төслийн санүүжилтэд хөрөнгө оруулагчдийг урьж оролцуулна.
13. Хөрөнгө оруулагчдийн эрх ашигт хүндэтгэлтэй хандана.

- ТӨСЛИЙН ҮРГЭЛЖЛЭЛ, ИРЭЭДҮЙ

Төслийн ирээдүйг бид өөдрөгөөр төсөөлж байна.

- Төслийн баг цаашид шинэ загварын “00” гүйлт бүхий шинэ авто машин ба бүрэн цахилгаан, байгаль орчин болон хүний эрүүл мэндэд ээлтэй авто машинжуулах бодлого баримтална.
- Мөн өөрийн нэр, хаяг, загвар бүхий эх орондоо угсарсан авто машин байна.
- Төсөлд оролцогсад улсынхаа машин үйлдвэрлэл, худалдааны тэргүүн байгууллага, компани болох зорилттой ажиллаж байна.

ГУРАВ: ЦААШДЫН ЗОРИЛТ:

Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ, ТУЗ-ийн дарга, гишүүд ээ.


Та бидний зорилт, зорилго өнөөдөр тун тодорхой байна. Хувьцаа эзэмшигчдийнхээ дунд зохион байгуулж байгаа төсөл арга хэмжээнүүдийн онцлогоос хамаарч Бид хамтдаа он удаан жил хамтран ажиллаж, амьдрах нөхцөл шаардлага бий болж байна.

1. Эхлүүлсэн төслүүдээ амжилттай хэрэгжүүлэн тогтворжуулах
2. Бидэнд итгэж компанийн том төслүүдэд хөрөнгө оруулалт хийж, итгэл сэтгэлээ өгсөн багш, эмч, хувьцаа эзэмшигчдээ орон сууцжуулах ажлыг хэрэгжүүлж дуусгах
3. БАГШ хотхон, ЭМЧ хотхоны төлөвлөлтүүдийг эхлүүлэх
4. Нэмэлт санхүүжүүлэлт, хөрөнгө татан төвлөрүүлэх ажлуудаа мэргэжлийн түвшинд удирдан зохион байгуулах

5. Төслийн дараагийн үе шатуудыг эхлүүлэх, хэрэгжүүлэх
6. Төслийг хөдөө орон нутагт эрчимтэй үргэлжлүүлэх

7. Бас нэгэн үндсэн төсөл болох орон сууц үйлдвэрлэл бүхий НОГООН ОТОГ төслийг хэрэгжүүлэх ажлууд зорилт болон хүлээж байна.

8. Газрыг эзийн засгийн эргэлтэнд оруулах, Хувьчилсан газраасаа ашиг олдог байх таатай нөхцлийн бүрдүүлсэн "ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХ, ӨМЧЛӨЛИЙН ГАЗРЫГ КОМПАНИЙН ХУВЬЦААНД ХӨРВҮҮЛЭН ҮНЭ ЦЭНИЙГ ӨСГӨХ, НЭГДМЭЛ БАЙДЛААР ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ТЭДГЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ"-ын хэрэгжилтийг эхлүүлэх ажил байна.



Хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд өссөн, үйл ажиллагаа өргөжин идэвхитэй явагдаж байгаа энэ үед компанийн үйл ажиллагааг эрчимтэй зохион байгуулж, боловсруулагдсан төсөл хөтөлбөрүүд болон гэрээ хэлэлцээрүүдийг бодит ажилруу оруулан хурдацтай хийж хэрэгжүүлэх явдал компанийн цаашдын үйл ажиллагааны зорилт болж байна.

АНХААРЛАА ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.

Тайлан илтгэсэн Гүйцэтгэх захирал


Н.Алтансүх